



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН  
СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.01.24 № 01/106

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендер түдгэлзүүлэх тухай

Танай эмнэлгээс зарласан “Компьютер томографын аппарат” худалдан авах ӨВАХХСНЭ/20240102010 дугаартай тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод холбогдох гомдлыг “Саммит медикал сервис” ХХК-аас тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58.2-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, техникийн тодорхойлолтод заасан техникийн үзүүлэлтийг ямар судалгаа, мэдээлэлд үндэслэн тусгасан талаарх тайлбар, баримтын хамт 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН